



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 25 өдөр

Дугаар А/232

Мандалговь

Цээж тооллын тамирчин болон бэлтгэсэн
багшид урамшуулал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар хэсгийн 2.1.4, аймгийн Засаг даргын 2022 оны А/88 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтаар батлагдсан “Урамшууллын жишиг тогтоох журам”-ын 1.7, 3.2.1 дахь заалт болон аймгийн Засаг даргын зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 09 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Америкийн Нэгдсэн улсын Сампингийн холбооноос зохион байгуулсан UAAA – GLOBAL CUP 2022 онлайн олон улсын тэмцээнд цээж тооллын төрлөөр 9 насны ангилалд алтан цомын болзол хангасан Тояа Хүүхэд Хөгжлийн академийн Дундговь салбарын суралцагч Энхбаярын Аялгууг 800,000 төгрөг, бэлтгэсэн багш Б.Бадамхандыг 560,000 төгрөгөөр тус тус шагнаж урамшуулсугай.

2. Урамшуулалд олгох 1,360,000 (Нэг сая гурван зуун жаран мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (Н.Энхмарт) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100388